



Өвөрхангай аймгийн Засаг даргын  
дэргэдэх Статистикийн хэлтэс



## Үйлдвэр үйлчилгээний салбарын өнөөгийн байдал



Арвайхээр

**ГАРЧИГ**

1. Аймгийн аж үйлдвэр барилгын салбарын үүсэл хөгжил .....	3
2. Аймагт бүртгэлтэй ААНэгжийн тоо .....	4-5
3. Сүүлийн жилүүдэд аж үйлдвэр, барилга үйлчилгээний салбарт гарч байгаа гол онцлог өөрчлөлт .....	6
4. Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт .....	7-8
5. Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн борлуулалт .....	9
6. Аймгийн газар зүйн байршил зах зээлд ойр эсэх .....	10-11
7. Аймгийн дэд бүтцийн хөгжил .....	12
8. Гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт .....	13
9. Хангайн аж үйлдвэр, барилга үйлчилгээний салбарын дотоодын нийт бүтээгдэхүүн, .....	14
10. Аж үйлдвэрийн салбарт ажилласадын хувь .....	15-16
11. Барилгын салбарын нийт үйлдвэрлэлт, их засварын ажлууд .....	17
12. Аж үйлдвэр, барилгын салбарын хөдөлмөрийн бүтээмж .....	18
13. Худалдаа, үйлчилгээний салбарын аймгийн днб-д эзлэх хувь .....	19-20
14. Техникийн үзлэгт хамрагдсан автомашины тоо .....	21-22
15. Холбоо үйлчилгээний орлого телефон цэгийн тоо .....	23-25
16. Дүгнэлт .....	26-27
17. Ашигласан ном, материал .....	28



## **Аймгийн аж үйлдвэр, барилга, үйлчилгээний салбарын үүсэл хөгжил**

Өвөрхангай аймаг 1942 онд Улсын бага хурлын шийдвэрээр 23 сум 177 баг, 15000 өрхтөйгөөр анх байгуулагдсан юм. Эдүгээ аймаг засаг захиргааны нэгжийн хувьд 19 сум, сум нь 109 багт хуваагддаг. 1991 оноос нийгэм бүхэлдээ өөрчлөгдөн улс орон зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж бүх салбарын төрийн өмч хувьчлагдан хувьд шилжсэнээр ихэнхи салбаруудад хувийн хэвшлийн оролцоо нэмэгдэж жижиг дунд үйлдвэрүүд шинээр байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна.

### Аж үйлдвэр

Аймгийн хүнсний үйлдвэр нарийн боов талх, чихэр, архины цехтэйгээр 1961 онд ашиглалтанд орсноор аймгийн ард иргэдийг үйлдвэрийн аргаар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр үйлчилж эхэлжээ.

Хархорин суманд 1972 онд спиртын үйлдвэр, 1983 онд хүнсний үйлдвэрүүд тус тус ашиглалтад орсон.

Баянтээгийн нүүрсний уурхай нь 1961 онд байгуулагдах үедээ жилд 20 мянган тонн нүүрс олборлох хүчин чадалтай байв. Ордны хайгуулын нөөц 160 сая тонн бөгөөд Өвөрхангай, Архангай, Баянхонгор аймгуудыг нүүрсээр хангадаг.

Уянга суманд үйл ажиллагаа явуулж буй 40-өөд алт олборлох нөхөн сэргээх чиглэлийн жижиг бичил уурхай эрхлэгч компаниуд үйл ажиллагаа явуулж байна.

1950 оны эхээр аймгийн төвд дизель цахилгаан станц ажиллуулж эхэлсэн ба 1965 онд Эрчим хүчний үйлдвэр болон өргөжүүлжээ.

1991 онд бүтцийн өөрчлөлтөөр нийтийн аж ахуйн үйлчилгээний газартай нэгтгэж аймгийн эрчим хүчний нэгдсэн үйлдвэр, 1995 оноос хойш Эрдэнэтийн цахилгаан шугам сүлжээний газрын харъяа Өвөрхангай аймгийн цахилгаан шугам сүлжээний салбар байгуулагдсан байна.

Төр засгийн зүгээс жижиг бизнесийг хөгжүүлэх ажлыг төрийн бодлого болгож, жижиг бизнес эрхлэх, шинээр үүсч бий болох таатай орчныг бүрдүүлж, үр ашигтай жижиг аж ахуйнуудыг цаашид хөгжин дэвшихэд нь дэмжин туслах зорилгоор хөтөлбөр боловсруулан тодорхой арга хэмжээнүүдийг авч явуулсны үр дүнд орон нутгийн зах зээлд тэдний үйлдвэрлэл нэмэгдэж байна.

2019 оны жилийн эцсийн байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн тоо 1430 байна. Үүний 205 буюу 14.3 хувь нь аж үйлдвэрийн салбарт, 828 буюу 57.9 хувь нь үйлчилгээний салбарт байна. Аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн 21.9 хувь нь уул, уурхай, олборлолт, 60.5 хувь нь боловсруулах үйлдвэрлэлд, 10.7 хувь нь цахилгаан хий, уур агааржуулалтын хангамжид, 3.4 хувь нь усан



хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаанд, 3.5 хувь нь барилгын салбар эзэлж байна.

### Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт

Аж үйлдвэрийн салбарын үйл ажиллагаа нь хүн амын хэрэглээ, дэд бүтэц болон ашигт малтмалын нөөц, уул уурхайн газар зүйн байршилаас илүү хамааралтай бөгөөд боловсруулах аж үйлдвэрийн салбар нь ихэнхдээ хүн амын хэрэглээг хангахад оршдог.

Аж үйлдвэрийн салбарт 2019 онд 55689.3 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өнгөрсөн оныхоос 14.7 хувиар буюу 8845.1 сая төгрөгөөр өссөн байна.


### Аймгийн аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт / сая.төг/

Хүснэгт-1

Үзүүлэлтүүд	2015	2016	2017	2018	2019	2019/2018%
<b>Уул уурхай, олборлох аж үйлдвэр</b>	<b>10353.1</b>	<b>12064.4</b>	<b>11246.3</b>	<b>10805.6</b>	<b>11567.9</b>	<b>107.1</b>
<b>Боловсруулах аж үйлдвэр</b>	<b>16218.8</b>	<b>16414.2</b>	<b>20086.2</b>	<b>30732.5</b>	<b>35276.2</b>	<b>114.8</b>
Хүнсний бүтээгдэхүүн	8045.6	8824	11209.6	13417.8	15331.6	114.3
Мод модон эдлэл	2001.7	1408.5	1670.9	1606.3	1638.4	102.0
Хэвлэл	39.6	50.8	41.1	57.0	60.1	105.4
Оёмол бүтээгдэхүүн	888.7	699.1	1058.3	1904.1	2883.5	151.4
Гутал	694.7	471.9	488.9	492.5	586.5	119.1
Тоосго	851.9	311.2	327	590.2	775.8	131.4
Блок	900.3	607.7	541.7	495.8	476.9	96.2
Бусад/ нүдний шил, хайрга, вакум цонх, төмөр хийц, угаасан ноос, гэх мэт/	2796.3	4041.0	4748.5	12168.3	13523.4	111.1
<b>Дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, хангамж усан</b>	<b>5797.3</b>	<b>5767.3</b>	<b>6269.3</b>	<b>7012.6</b>	<b>8845.2</b>	<b>126.1</b>
<b>Нийт дүн</b>	<b>32369.2</b>	<b>34245.9</b>	<b>37601.8</b>	<b>48550.8</b>	<b>55689.3</b>	<b>114.7</b>



Зураг-1

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний  
үйлдвэрлэлтийн эзлэх хувь, салбараар

Нийт үйлдвэрлэлийн 20.8 хувийг уул уурхай, олборлох аж үйлдвэр, 63.3 хувийг боловсруулах аж үйлдвэр, 15.9 хувийг дулааны эрчим хүч, усан хангамж эзэлж байна.

Хангайн бүсийн аймгуудын аж үйлдвэрийн салбарын  
нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл, оны үнээр, сая төг

Хүснэгт-2

	2018	2019	2019/2018 %
Архангай	6249.5	6479.6	103.7
Баянхонгор	13636.9	41071.9	3.0 дах
Булган	9512.2	7081.3	74.4
Орхон	2215735.6	2162580.3	97.6
Өвөрхангай	48550.8	55689.3	114.7
Хөвсгөл	28214.0	19732.4	69.9
<b>Хангайн бүс</b>	<b>2315649.5</b>	<b>2292634.8</b>	<b>99.0</b>

Хангайн бүсийн аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл өмнөх оныхоос 23014.7 сая.төг буюу 1.0 хувиар буурсан байна. Хангайн бүсийн нийт үйлдвэрлэлийн 0.3 хувийг Архангай аймаг, 1.8 хувийг Баянхонгор аймаг, 0.3 хувийг Булган аймаг, 0.9 хувийг Хөвсгөл аймаг, 94.3 хувийг Орхон аймаг, 2.4 хувийг манай аймаг эзэлж байна. Баянхонгор аймгийн нийт үйлдвэрлэл өссөн гол шалтгаан нь алт олборлолт ихээр өссөн нь голлон нөөлөөлсөн байна.






2230.1 сая төгрөг буюу 7.3 хувиар, дулаан эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж 1832.6 сая төгрөг буюу 26.1 хувиар тус тус өсчээ.

Зураг-2

## Нийт борлуулалт, сая.төг



## Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт

Хүснэгт-4

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2016	2017	2018	2019	2019/2018%
Талх	тн	503.3	555.9	447.1	477.4	106.8
Нарийн боов	тн	476	451	496.5	459.9	92.6
Архи	мян.л	25.3	28.4	41.2	32.2	78.2
Бялуу	тн	9.2	9.5	24.1	33.3	138.2
Цэвэр ус	тн	4942.7	6555.3	7579.2	8743.7	115.4
Сүү, тараг, хоормог	мян.л	168.4	189.3	51.8	46.8	90.3
Хэрчсэн гурил, банш,	тн	97.4	107.6	177.1	175.6	99.2
Хиам	тн	15	14.8	9	9.4	104.4
Даршилсан ногоо	тн	3.6	5	1.1	1.3	118.2
Дулаан	мян.г.кл	129.8	139.9	156.1	182.9	117.2
Түгээсэн ус, сувагжуулалт	мян/м3	399.8	444.7	452.7	534.1	118.0
Нүүрс	мян.тн	149.3	160	167.3	209.9	125.5
Алт	кг	129.6	105.3	73.3	56.1	76.5
Гэрийн мод	шир	1306	1245	1513	1365.0	90.2
Хүснэгт, маягт	мян.ш х	117.8	109.1	149.3	156.1	104.6
Гутал	хос	5508	5628	5368	5268.0	98.1
Тоосго	мян,ш	972.5	1242	2491.3	2338.4	93.9
Блок	мян.ш	602.8	524.6	443.2	404.1	91.2
Угаасан ноос	тн	1628.3	1950.6	1873.6	1575.8	84.1



Аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг авч үзэхэд талх 6.8 хувиар, бялуу 38.2 хувиар, цэвэр ус 15.4 хувиар, хиам 4.4 хувиар, даршилсан ногоо 18.2 хувиар, дулаан үйлдвэрлэл 17.2 хувиар, түгээсэн ус, сувагжуулалт 18.0 хувиар, нүүрс 25.5 хувиар, хүснэгт маягт 4.6 хувиар тус тус өсчээ. Харин нарийн боов 7.4 хувиар, архи 21.8 хувиар, Хэрчсэн гурил, банш 0.8 хувиар, алт 23.5 хувиар, гэрийн мод 9.8 хувиар, гутал 1.9 хувиар, тоосго 6.1 хувиар, блок 8.8 хувиар буурсан байна.

### Хангайн бүсийн аймгуудын дотоодын нийт бүтээгдэхүүн, оны үнээр


Хүснэгт-5

	2018				2019*			
	ДНБ, сая төг	Дүнд эзлэх хувь			ДНБ, сая төг	Дүнд эзлэх хувь		
		Хөдөө аж ахуй	Аж үйлдвэр, барилга	Үйлчилгээ		Хөдөө аж ахуй	Аж үйлдвэр, барилга	Үйлчилгээ
Архангай	431367.3	55.1	20.8	24.1	556790.0	59.5	18.7	21.8
Баянхонгор	417659.1	44.3	25.9	29.9	476761.7	45.0	26.2	28.8
Булган	318533.9	51.2	24.0	24.8	365829.7	53.4	21.9	24.8
Орхон	1871485.7	0.7	88.3	11.0	2080088.6	0.8	88.3	10.9
Өвөрхангай	502110.6	43.1	25.5	31.4	606108.5	44.0	26.9	29.0
Хөвсгөл	617305.8	41.7	30.5	27.9	720171.2	43.8	29.8	26.4
<b>Хангайн бүс</b>	<b>4158462.3</b>	<b>25.8</b>	<b>54.0</b>	<b>20.3</b>	<b>4805749.6</b>	<b>27.9</b>	<b>52.5</b>	<b>19.6</b>
<b>Улсын дүн</b>	<b>32411224.1</b>	<b>7.7</b>	<b>35.1</b>	<b>57.2</b>	<b>36897640.2</b>	<b>7.9</b>	<b>35.2</b>	<b>56.9</b>

Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн өмнөх оныхоос 103997.9 сая төгрөг буюу 20.7 хувиар өсчээ. Хангайн бүсийн дотоодын нийт бүтээгдэхүүний 12.6 хувийг аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн эзэлж байна. Энэ нь өмнөх оныхоос 0.6 пунктээр өссөн байна. Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 13.0 хувийг хангайн бүс, 1.6 хувийг аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн эзэлж байна. Хангайн бүсийн дотоодын нийт бүтээгдэхүүний 11.6 хувийг Архангай аймаг, 9.9 хувийг Баянхонгор аймаг, 7.6 хувийг Булган аймаг, 43.3 хувийг Орхон аймаг, 15.0 хувийг Хөвсгөл аймаг, 12.6 хувийг Өвөрхангай аймаг эзэлж байна.



## Аймгийн ДНБ-ний дүнд салбарын эзлэх хувь



2019 оны аймгийн ДНБ-ний 44.0 хувийг хөдөө аж ахуйн салбар, 26.9 хувийг аж үйлдвэр, барилгын салбар, 29.0 хувийг үйлчилгээний салбар тус тус эзэлж байна. Дотоодын нийт бүтээгдэхүүнд салбаруудын эзлэх хувь өмнөх оныхоос хөдөө аж ахуй 0.9 пунктээр, аж үйлдвэр, барилга 1.4 пунктээр өсч, үйлчилгээнийх 2.4 пунктээр буурсан байна.

#### Аймгийн нийт ажиллагсадын тоонд аж үйлдвэр, барилгын салбарт ажиллагсадын эзлэх хувь


2019 оны байдлаар аймгийн нийт ажиллагсадын тоо өмнөх оныхоос 7434 хүнээр буюу 13.3 хувиар буурсан байна. Аж үйлдвэр, барилгын салбарт ажиллагсадын тоо өмнөх оныхоос 1300 хүнээр буюу 15.7 хувиар буурчээ.

Хүснэгт-6

Дэд салбаруудаар	2016	2017	2018	2019	2019/2018 %
Уул уурхай	1568	2045	2001	1831	91.5
Боловсруулах үйлдвэр	3087	1889	3200	2437	76.2
Цахилгаан,дулааны эрчим хүч	347	533	854	488	57.1
Барилга	1144	1953	2237	2236	100.0
Аж үйлдвэр, барилгын салбарт ажиллагсад	6146	6420	8292	6992	84.3
Нийт ажиллагсад	49583	55181	55882	48448	86.7



Аж үйлдвэр, барилгын салбарт ажиллагсадын тоонд салбарын ажиллагсадын эзлэх хувь



Аж үйлдвэр, барилгын салбарт ажиллагсадын 26.2 хувь нь уул уурхайд, 34.8 хувь нь боловсруулах үйлдвэрт, 7.0 хувь нь цахилгаан, дулааны эрчим хүчинд, 32.0 хувь нь барилгад ажиллаж байна.

#### Аж үйлдвэр, барилгын салбарын хөдөлмөрийн бүтээмж

Хөдөлмөрийн бүтээмж нь улс оронд бий болсон үйлдвэрлэл, үйлчилгээний үр ашгийн үзүүлэлт бөгөөд нэгж зардлаар хэдий хэр бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэж байгааг тодорхойлдог.

Хөдөлмөрийн бүтээмжийг тооцохдоо нэмэгдэл өртгийн хэмжээг жилийн дундаж ажиллагчдын тоонд хувааж гаргадаг. Аймгийн аж үйлдвэр, барилгын салбарын хөдөлмөрийн бүтээмжийн хэмжээ өмнөх оноос 51.3 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт-10

Үзүүлэлт	2015	2016	2017	2018	2019	2019/2018 %
Аж үйлдвэр, барилгын салбарын дотоодын нийт бүтээгдэхүүн/ сая төг/	70027.5	76441.1	100628.4	128038.2	163043.1	127.3
Аж үйлдвэр, барилгын салбарын ажиллагсадын дундаж тоо	5246	6146	8428	8292	6992	84.3
Үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн бүтээмж	13.3	12.4	11.9	15.4	23.3	151.3




## Техникийн үзлэгт хамрагдсан автомашины тоо, бүсээр 2015-2019 он

Хүснэгт-11

Аймаг сум	2015	2016	2017	2018	2019
Улсын дүн	482049	499152	536399	585363	614753
Хангайн бүс	49331	51191	53649	54783	80946
Архангай	5435	5654	5937	6135	10947
Баянхонгор	5917	5289	5280	4986	11528
Булган	7100	7700	7980	7896	8958
Өвөрхангай	6010	5858	5678	5346	14887
Хөвсгөл	10593	10799	10862	11194	16188
Орхон	14276	15891	17912	19226	18438

Зураг -5

## Өвөрхангай аймгийн автомашины тоо, төрлөөр 2015-2019 он





## Холбооны салбарын үзүүлэлтүүд 2015-2019 он

Хүснэгт-12

	2015	2016	2017	2018	2019
Харилцаа холбооны үйлчилгээний орлого, мян.төг	581.6	653.1	645.5	676.4	659.6
Үүнээс: Хүн амаас орсон орлого, мян.төг	163.2	221.0	193.6	82.9	39.2
Суурин утасны цэг	976	736	663	629	635
Үүнээс: Өрхийн хэрэглэгч	505	437	224	170	154
Кабелийн телевизийн хэрэглэгчдийн тоо	3556	3884	3980	3293	3366
Интернэтээр үйлчлүүлэгчдийн тоо	10800	9198	9165	9026	5785
Үүнээс: Албан байгууллага	137	184	190	173	163
Айл өрх, хувь хэрэглэгч	508	430	450	175	134
Интернэтийн орлого	136.3	201.2	228.7	244.1	232.0

Зураг-6



Харилцаа холбооны салбар эрчимтэй хөгжиж байгаа өнөө үед манай аймагт үүрэн телефоны сүлжээ операторууд болох Мобиком, Юнител, Жи-мобайл, Скайтель зэрэг компанийн салбарууд үйл ажиллагаа явуулж, хэрэглэгчдийг олноор нь татсаар байгаа билээ. Үүнтэй холбоотойгоор суурин утас хэрэглэгчдийн тоо өмнөх онуудыг бодвол эрс буурсан байна. 2019 онд суурин утасны цэгийн тоо 635 болж, өмнөх оныхоос 6-аар нэмэгджээ. Кабелийн телевизийн хэрэглэгчдийн тоо 3366 болж өмнөх оноос 73 хэрэглэгчээр өссөн байна. Холбооны байгууллагууд 659.6 сая төгрөгийн орлоготой



ажилласны 5.9 хувийг хүн амын үйлчилгээний орлого эзэлж байна. Өнгөрсөн оноос нийт орлого 2.5 хувиар буюу 16.8 сая.төгрөгөөр буурчээ. Интернетээр үйлчлүүлэгчдийн тоо 5785 болж өнгөрсөн оныхоос 36.0 хувиар буурсан ба интернэтийн үйлчилгээнээс орсон орлого 232.0 сая төгрөг болж өмнөх оноос 5.0 хувиар буурсан байна.


### Холбооны салбарын нийт орлого, хангайн бүсийн аймгуудаар, 2015-2019 он

Хүснэгт-13

Аймгийн нэр	2015	2016	2017	2018	2019
Хангайн бүс	4995.4	4931.3	4675.2	4895.1	5341
Архангай	380.3	355.1	410.1	432.6	454.5
Баянхонгор	694.7	505.6	558.2	673.3	704.3
Булган	504	512	475.1	498.7	534.7
Өвөрхангай	688.3	778.1	711.9	786.7	785.7
Хөвсгөл	573	614.4	507.6	584	844.3
Орхон	2155.3	2166.1	2012.3	1920	2017.4

Зураг-7

### Тээвэр, Холбоо, Агуулахын салбарт ажиллагсад 2015-2019 он



### ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, АЙМГИЙН ДНБ-Д ЭЗЛЭХ ХУВЬ

Аймгийн хэмжээнд дотоодын нийт бүтээгдэхүүний тооцоонд бизнес регистрийн санд бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж аж ахуй нэгж болон түүвэр судалгааны мэдээлэл, бусад мэдээллийн эх үүсвэрийг ашиглан тооцсон.




2019 онд дотоодын нийт бүтээгдэхүүн урьдчилсан гүйцэтгэлээр 606108.5 сая төгрөгт хүрсний 175771.5 сая төгрөг буюу 29.0 хувь нь худалдаа, үйлчилгээний салбарт бий болсон байна.

### 1. ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ДНБ-НИЙ ГҮЙЦЭТГЭЛ, сая төгрөгөөр

он	2016	2017	2018	2019	2019/2018	
					зөрүү	%
<b>Бүгд ДНБ</b>	<b>404737.3</b>	<b>460298.6</b>	<b>502110.6</b>	<b>606108.5</b>	103997.9	120.7
Худалдаа, үйлчилгээний салбар	129920.7	143152.9	157662.7	175771.5	18108.8	111.5
ДНБ-д эзлэх хувь	32.1	31.1	31.4	29.0		

Аймгийн нийт дотоодын нийт бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеийнхээс 103997.9 сая төгрөгөөр буюу 20.7 хувиар өссөн бол 2017 оныхоос 145809.9 сая төгрөгөөр буюу 31.7 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

**Дотоодын нийт бүтээгдэхүүн 2016-2019 оноор  
/сая.төг/**





Худалдаа, үйлчилгээний салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь урьдчилсан гүйцэтгэлээр 2019 онд 29.0 хувь болж өмнөх оноос 2.4 пунтаар буурсан үзүүлэлттэй байна.

### ДҮГНЭЛТ, САНАЛ

Хэдийгээр аймгийн аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлт, борлуулалтын хэмжээ жилээс жилд нэмэгдэж байгаа боловч бүтээгдэхүүний чанар, өнгө үзэмж, хаяг шошгын асуудал шаардлага бүрэн хангаж чадахгүй байгаа юм. Аймгийн хэмжээнд төдийгүй бусад зэргэлдээ аймаг цаашлаад хил худалдаагаар гаргах хэмжээний үйлдвэрлэл явуулж чадахгүй байна. Анх 1940-өөд онд байгуулагдсан Хүнсний үйлдвэр талх, нарийн боов, архи үйлдвэрлэлт голлон үйлдвэрлэдэг ч чанартай холбоотойгоор бүтээгдэхүүний борлуулалт хангалттай биш. Нөгөө талаар хувийн худалдаа эрхлэгчид УБ хотоос бүтээгдэхүүн их хэмжээгээр оруулж ирж худалдаалж байгаа нь орон нутгийн үйлдвэрлэгчдийн борлуулалтад шууд нөлөөлж байна. 2008 оны үед зах зээлийн хөгжил хүн амын хандлагаа дагаад архины олон үйлдвэрүүд бий болж аж үйлдвэрийн бүтээгдэхүүний өсөлтийг нэмэгдүүлж харагдаж байсан. Харин сүүлийн жилүүдэд орон нутгаас хяналтыг сайжруулж ихэнхийг нь хаасан. Уул уухайн чиглэлээр Баянтээгийн нүүрсний уурхай аж үйлдвэрийн салбарт голлох нөлөөтэй үйлдвэр юм. Аймгийн төдийгүй хил залгаа Баянхонгор, Архангай аймагт нийлүүлэлт хийдэг, эрэлтийг хангах хэмжээний нөөцтэй.

Сүүлийн жилүүдэд тус аймгийн нутаг дэвсгэрт аж ахуйн нэгжүүд алт олборлолтийн үйл ажиллагаа явуулж байгаа хэдий ч аймгийн төсөв, орон нутгийн орлогод бага нөлөө үзүүлдэг. Ихэнх нь УБ хотын харъяат аж ахуйн нэгжүүд байдагтай холбоотой. Мөн барилгын хөгжлийг дагаад блок, тоосго үйлдвэрлэх жижиг үйлдвэрлэгчид бий болж байна. Тээврийн зардал багатай талаас нь харгалзаж хэрэглэгчдэд өртөг бага тусч байгаагаас борлуулалт





Ашигласан материал, номзүй

- ӨВ Статистикийн эмхэтгэл 2013-2019 он
- Макро эдийн засгийн статистик 2007 он
- Монгол улсын статистикийн эмхэтгэл-2015-2019
- [www.1212.mn](http://www.1212.mn)

